



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ДУЛААН ШАРЫН ГОЛ ТӨХК-ИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД  
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/105/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор  
Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер: Ц.Хосжаргал  
Утас: 261885 Цахим хаяг: [khosjargalts@audit.gov.mn](mailto:khosjargalts@audit.gov.mn)  
Аудитор: Э.Бүгүнэтэй  
Утас: 260512 Цахим хаяг: [bugunuteie@audit.gov.mn](mailto:bugunuteie@audit.gov.mn)  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Шинэ их тэрбум аудит" ХХК  
Захирал: Ц.Мишигдорж  
Цахим хаяг: [ikhterbum@gmail.com](mailto:ikhterbum@gmail.com)

Улаанбаатар хот  
2022 он

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт .....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	7
3. Аудитын тайлан.....	8
3.1 Ерөнхий зүйл.....	8
3.2 Дотоод хяналт.....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	8
3.4 Материаллаг байдал .....	9
4. Санхүүгийн тайлангийн тодруулга .....	9
Байгууллагын үйл ажиллагаа .....	9
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	9
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого .....	10
4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	11
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	12
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	12
5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	13
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	13
8. Аудитын илрүүлэлт .....	13
8.1 Залруулсан алдаа .....	14
8.2 Төлбөрийн акт.....	14
8.3 Албан шаардлага .....	14
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	15

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ДУЛААН ШАРЫН ГОЛ ТӨХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.БАТХУЯГ  
ТАНАА

2022.03.15 № 07/570  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -г

Хараат бус аудиторын тайлан

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дулаан шарын гол ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дулаан шарын гол ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон зүйл

Дархан Сэлэнгийн Цахилгаан түгээх сүлжээ ХК-ийн цахилгаан эрчим хүч хэрэглэсний төлбөрийг гаргуулах нэхэмжлэлтэй иргэний хэргийн шүүх хуралдааны тогтоолоор 545.7 сая төгрөгийг Дулаан шарын гол ТӨХК төлж барагдуулахаар шийдвэрлэснээс 147.1 сая төгрөгийг барагдуулж, үлдэгдэл 398.6 сая төгрөгийн төлбөрийг барагдуулах хуваарийг нэхэмжлэгч талд хүргүүлсэн байна.

### Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Эрчим хүчний сайдын 2021 оны А/25 дугаар тушаалаар эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нийт орлогыг 3,104.7 сая төгрөгөөр, нийт зардлыг 3,650.0 сая төгрөгөөр, алдагдлыг 545.3 сая төгрөг байхаар баталсан байна. Эрчим хүчний сайдын 2021 оны А/164 дугаар тушаалаар нийт орлогыг 44.8 сая төгрөгөөр бууруулж, алдагдлыг 44.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна.

Гүйцэтгэлээр 3,032.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 3,216.8 сая төгрөгийн зардал гарган, 184.7 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

### **Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Компани нь 2021 онд 10 зорилтын хүрээнд 37 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэл 100 хувьтай гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

				/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31		
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>				
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>				
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,746,589.46	3,277,401.03		
1.1.02	Дансны авлага	324,764,677.79	428,951,169.95		
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	0.00	0.00		
1.1.04	Бусад авлага	4,736,904.50	4,736,904.50		
1.1.05	Бусад санхүүгийн хөрөнгө	0.00	0.00		
1.1.06	Бараа материал	102,042,226.61	76,667,431.68		
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	81,881,478.97	50,038,331.08		
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>515,171,877.33</b>	<b>563,671,238.24</b>		
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>				
1.2.01	Үндсэн хөрөнгө	6,209,952,367.33	6,437,348,511.42		
1.2.02	Биет бус хөрөнгө	96,983,999.86	114,699,590.30		
1.2.03	Биологийн хөрөнгө	3,230,000.00	3,230,000.00		
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>6,310,166,367.19</b>	<b>6,555,278,101.72</b>		
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>6,825,338,244.52</b>	<b>7,118,949,339.96</b>		
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>				
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>				
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>				
2.1.1.01	Дансны өглөг	739,281,748.39	744,523,456.62		
2.1.1.03	Татварын өр	543,310,589.90	649,807,480.68		
2.1.1.04	НДШ - ийн өглөг	350,822,571.78	422,277,728.38		
2.1.1.05	Богино хугацаат зээл	150,000,000.00	0.00		
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	1,295,170.23	2,998,220.24		
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>1,784,710,080.30</b>	<b>1,819,606,885.92</b>		
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>				
2.1.2.04	Бусад урт хугацаат өр төлбөр	27,476,052.34	18,432,989.98		
<b>2.1.2.06</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>27,476,052.34</b>	<b>18,432,989.98</b>		
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>1,812,186,132.64</b>	<b>1,838,039,875.90</b>		
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>				
2.3.01	Өмч: - төрийн	6,525,993,994.35	6,525,993,994.35		
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	884,047,508.32	916,710,028.32		
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	89,304,000.00	508,162,728.28		
2.3.09	Хуримтлагдсан ашиг	(2,486,193,390.79)	(2,669,957,286.89)		
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	(184,655,448.10)		
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	2,486,193,390.79)	(2,485,301,838.79)		
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>5,013,152,111.88</b>	<b>5,280,909,464.06</b>		
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>6,825,338,244.52</b>	<b>7,118,949,339.96</b>		

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
01	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	2,831,775,052.58	2,831,835,993.07
02	Борлуулалтын өртөг	3,215,260,769.15	2,991,387,925.01
<b>03</b>	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	<b>(383,485,716.57)</b>	<b>(159,551,931.94)</b>
05	Хүүний орлого	307,473.75	
08	Бусад орлого	209,471,553.28	200,292,582.17
<b>08.1</b>	<b>Орлогын дүн</b>	<b>209,779,027.03</b>	<b>200,292,582.17</b>
10	Ерөнхий ба удирдлагын зардал	169,720,995.06	169,434,111.46
12	Бусад зардал	114,336,235.68	55,961,986.87
<b>12.1</b>	<b>Зардлын дүн</b>	<b>284,057,230.74</b>	<b>225,396,098.33</b>
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)</b>	<b>(457,763,920.28)</b>	<b>(184,655,448.10)</b>
19	Орлогын татварын зардал	30,747.38	
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(457,794,667.66)</b>	<b>(184,655,448.10)</b>
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)		
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>(457,794,667.66)</b>	<b>(184,655,448.10)</b>
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
<b>24</b>	<b>Орлогын нийт дүн</b>	<b>(457,794,667.66)</b>	<b>(184,655,448.10)</b>
<b>25</b>	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2019 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл</b>	<b>6,525,993,994.35</b>	<b>850,017,239.82</b>	<b>89,304,000.00</b>	<b>(2,028,398,723.13)</b>	<b>5,436,916,511.04</b>
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>6,525,993,994.35</b>	<b>850,017,239.82</b>	<b>89,304,000.00</b>	<b>(2,028,398,723.13)</b>	<b>5,436,916,511.04</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(457,794,667.66)	(457,794,667.66)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	34,030,268.50	-	-	34,030,268.50
<b>2020 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл</b>	<b>6,525,993,994.35</b>	<b>884,047,508.32</b>	<b>89,304,000.00</b>	<b>(2,486,193,390.79)</b>	<b>5,013,152,111.88</b>
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>6,525,993,994.35</b>	<b>884,047,508.32</b>	<b>89,304,000.00</b>	<b>(2,486,193,390.79)</b>	<b>5,013,152,111.88</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(184,655,448.10)	(184,655,448.10)
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	418,858,728.28	-	418,858,728.28
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	32,662,520.00	-	891,552.00	32,662,520.00
<b>2021 оны 12 сарын 31-р үлдэгдэл</b>	<b>6,525,993,994.35</b>	<b>916,710,028.32</b>	<b>508,162,728.28</b>	<b>(2,669,957,286.89)</b>	<b>5,280,909,464.06</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	<b>2,082,288,263.78</b>	<b>2,170,428,201.77</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,478,436,291.87	1,629,720,338.79
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	482,000,000.00	491,700,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	121,851,971.91	49,007,862.98
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>2,017,383,754.57</b>	<b>1,953,140,490.20</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,130,002,333.42	942,869,468.91
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	181,217,527.78	241,776,326.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	347,236,828.85	249,586,863.57
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	4,676,640.00	168,293,562.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	46,457,022.10	58,374,214.21
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	22,877,277.97	9,322,524.95
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	144,900,731.05	146,347,228.59
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	3,325,000.00	2,036,565.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	136,690,393.40	134,533,736.97
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>64,904,509.21</b>	<b>217,287,711.57</b>
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	<b>307,473.75</b>	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	307,473.75	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>33,554,981.80</b>	<b>65,756,900.00</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	33,554,981.80	65,756,900.00
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(33,247,508.05)</b>	<b>(65,756,900.00)</b>
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	<b>150,000,000.00</b>	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	150,000,000.00	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>180,920,951.21</b>	<b>150,000,000.00</b>
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	180,920,951.21	150,000,000.00
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(30,920,951.21)</b>	<b>(150,000,000.00)</b>
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>736,049.95</b>	<b>1,530,811.57</b>
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	<b>1,010,539.51</b>	<b>1,746,589.46</b>
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	<b>1,746,589.46</b>	<b>3,277,401.03</b>

## 2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Үйлдвэрлэсэн: Дулааны эрчим хүч	Гкал	38,868.7	38,050.0	38,814.8	764.8	102.0
	Түгээсэн: Дулааны эрчим хүч	Гкал	35,648.4	34,830.0	35,594.8	764.8	102.2
2	Олборлох ус	м3		351,734.0	306,825.0	(44,909.0)	87.2
	Үүнээс: Нэмэлт усны зарцуулалт	м3		26,150.0	19,334.0	(6,816.0)	73.9
	Гал түймэр унтраахад хэрэглэх ус	м3		100.0	100.0	-	100.0
	Борлуулах ус	м3		262,171.9	232,162.5	(30,009.4)	88.6
	Зайлуулах бохир ус	м3		309,304.8	251,588.0	(57,716.8)	81.3
3	<b>Нийт орлого</b>	<b>мян.төг</b>	<b>3,041,554.0</b>	<b>3,059,949.7</b>	<b>3,032,128.6</b>	<b>(27,821.1)</b>	99.1
	Үүнээс: Цэвэр борлуулалт	мян.төг	2,393,593.2	2,484,740.0	2,384,836.0	(99,904.0)	96.0
	Үйл ажиллагааны бус орлого	мян.төг	209,779.0	128,118.8	200,292.6	72,173.8	156.3
	Санхүүжилт	мян.төг	438,181.8	447,090.9	447,000.0	(90.9)	100.0
4	<b>Нийт зардал</b>	<b>мян.төг</b>	<b>3,418,751.3</b>	<b>3,650,006.7</b>	<b>3,216,784.0</b>	<b>(433,222.7)</b>	88.1
	Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	102,246.4	103,004.7	101,607.7	(1,397.0)	98.6
5	Татварын өмнөх ашиг	мян.төг	(457,764.0)	(590,057.0)	(184,655.4)	405,401.6	31.3
6	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	(457,794.7)	(590,057.0)	(184,655.4)	405,401.6	31.3
7	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	мян.төг	1.50	1.47	1.35	(0.12)	91.8
8	Нийт авлага	мян.төг	329,501.6	110,533.9	433,688.1	323,154.2	392.4
9	Нийт өглөг	мян.төг	1,812,186.1	1,277,797.4	1,819,606.9	541,809.5	142.4
	Богино хугацаат өр төлбөр	мян.төг	1,784,710.1	1,277,797.4	1,819,606.9	541,809.5	142.4
	Урт хугацаат өр төлбөр	мян.төг	27,476.0				
10	Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалт	мян.төг	128,537.2	104,672.3	94,699.1	(9,973.2)	90.5
	Жишмэл түлшний хувийн зарцуулалт	кг/Гкал		195.2	196.0	0.8	100.4
11	Нийт ажиллагсдын тоо	хүн	111.0	108.0	98.0	(10.0)	90.7
12	Нийт цалингийн сан	мян.төг	1,250,251.0	1,307,221.9	1,026,019.7	(281,202.2)	78.5
13	Нэг ажиллагчийн дундаж цалин /жүд/	мян.төг	938.6	1,008.7	872.5	(136.2)	86.5



### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дулаан шарын гол ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 15-аас 03 дугаар сарын 15-ны хооронд Шинэ их тэрбум аудит ХХК-ийн ахлах аудитор Т.Меруерт, Т.Тогтохбаяр, аудиторын туслах М.Оюунтуяа нар гүйцэтгэж, хяналтыг менежер Д.Дашдулам, захирал Ц.Мишигдорж хэрэгжүүлсэн.

Дулаан шарын гол ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 01/52 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд дотоод хяналтын мэргэжилтэн нь дотоод хяналтыг хууль тогтоомжийн хэрэгжилт, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн төлөвлөгөөний гүйцэтгэл, байгаль орчны нөхөн сэргээлтэд хяналт тавих үндсэн 5 бүлэг, 33 чиглэлийн хүрээнд зохион байгуулсан байна. Дотоод хяналтын үр дүнг тухай бүр гүйцэтгэх захирал, захирлын зөвлөлийн хуралд танилцуулан хуулийн хэрэгжилт, санхүүгийн үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн төлөвлөгөө, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах чиглэлээр 13 зөвлөмж өгч, гарсан алдаа, дутагдлыг арилгуулж ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагатай гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Дулаан шарын гол ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 3,499.3 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 35.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## 4. Санхүүгийн тайлангийн тодруулга

### Байгууллагын үйл ажиллагаа

Дулаан шарын гол ТӨХК-ийн зорилго нь хэрэглэгчдийг стандартын шаардлагад нийцсэн дулааны эрчим хүч, ундны цэвэр усаар тасралтгүй найдвартай хангах, бохир усыг ариутган татан зайлуулах ба эдийн засгийн үр ашигтай ажиллахад оршино. Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дулаан эрчим хүч үйлдвэрлэх, түгээх, дулааны эрчим хүчээр зохицуулалттай хангах, цэвэр ус олборлох, түгээх, бохир ус татан зайлуулах, усны тоолуур суурилуулах, засварлах, 0,7-16,0 кгс/см даралттай зуухны угсралт, засвар түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ хийх гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд төрийн өмчит хувьцаат компани гэсэн статустай байна. Өмчийн 100.0 хувийг төр эзэмшдэг, үүнээс ТӨБЗГ 30.0 хувь, Эрчим хүчний яам 70.0 хувийг эзэмшиж байна.

### 4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Дулаан шарын гол ТӨХК нь Төрийн өмчийн хорооны 2010 оны 121 дүгээр тогтоолыг үндэслэн байгуулагдсан байна.

Дулаан шарын гол ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг сард 1 хүнд 0.5 сая төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалтай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд Төрийн өмчийн бүртгэл хөтлөлт, зах зээлийн үнэлгээг шинэчлэн тогтоох чиглэлээр компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгүүдийг дахин үнэлэх ажлыг зохион байгуулж баланст бүртгэсэн байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн өөрчилж, чиг үүргийн давхардлыг арилгаж орон тоог 10 нэгжээр бууруулсан, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан үндэслэлтэй тогтоосон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Эрчим хүчний салбарын 2021-2022 оны хамтын хэлэлцээр;
- Засгийн газрын 2021 оны 207 дугаар тогтоол “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай”;
- Эрчим хүчний сайдын 2021 оны А/97 дугаар тушаалаар баталсан “Эрчим хүчний салбарын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тушаал, шийдвэр болон бусад баримт бичгийн хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”;
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”;
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”.

### 4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Дулаан шарын гол ТӨХК-ийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,746.6	3,277.4	1,530.8
Авлага	329,501.6	433,688.1	104,186.5
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	81,881.5	50,038.3	(31,843.2)
Бараа материал	102,042.2	76,667.4	(25,374.8)
Үндсэн хөрөнгө	6,209,952.4	6,437,348.5	227,396.1
Биет бус хөрөнгө	96,984.0	114,699.6	17,715.6
Биологийн хөрөнгө	3,230.0	3,230.0	-
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>6,825,338.3</b>	<b>7,118,949.3</b>	<b>293,611.0</b>
Богино хугацаат өглөг	1,784,710.1	1,819,606.8	34,896.7
Урт хугацаат өглөг	27,476.1	18,433.0	(9,043.1)
Эздийн өмч	5,013,152.1	5,280,909.5	267,757.4
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>6,825,338.3</b>	<b>7,118,949.3</b>	<b>293,611.0</b>

Банк дахь харилцах дансанд байгаа 3.3 сая төгрөг байна.

Тайлант онд Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолын хүрээнд зарим хэрэглэгчдийн төлбөрийг төр хариуцсантай холбоотой төрөөс авах авлага 61.9 сая төгрөгөөр, аж ахуйн нэгж байгууллага, айл өрх, төсвийн байгууллагаас авах борлуулалтын авлага 42.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь авлагын өсөлтөд голлон нөлөөлжээ.

Авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа 251.4 сая төгрөгийн, хугацаа хэтэрсэн шүүхийн шийдвэртэй 177.5 сая төгрөгийн авлага, 365 хоногоос дээш хугацаанд төлөгдөөгүй 4.7 сая төгрөгийн бусад авлага байна.

Тайлант онд худалдан авах төлөвлөгөөний дагуу хийгдсэн ажил, урсгал засвар, тоног төхөөрөмжийн төлбөрт 23.3 сая төгрөгийн урьдчилгаа шилжүүлсэн байна. Урьдчилгаа данснаас тайлант онд ажлын гүйцэтгэлийг дүгнэн, акт үйлдэж 139.0 сая төгрөгийг үндсэн хөрөнгө, сэлбэг материал, урсгал засварын холбогдох дансанд шилжүүлэн бүртгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 76.7 сая төгрөг болж 25.3 сая төгрөгөөр буурсан нь үндсэн сэлбэгийн зарцуулалт өссөн, шаардлага хангахгүй бараа материалыг акталснаас шалтгаалжээ.

Тайлант онд худалдан авалтаар 586.4 сая төгрөгийн түүхий эд материал, 62.7 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 4.5 сая төгрөгийн бичиг хэргийн материал, 115.5 сая төгрөгийн хангамжийн материал, 38.8 сая төгрөгийн хөдөлмөр хамгааллын хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй 14.3 сая төгрөгийн нөөцийн бараа материал байна. Энэ нь гэнэтийн нөхцөл байдалд зайлшгүй бэлэн байлгах ёстой сэлбэг хэрэгслүүдээс бүрдэж байна.

Үндсэн хөрөнгө худалдан авсан 156.9 сая, хөрөнгийн дахин үнэлгээ хийлгэсэн 32.1 сая, тоног төхөөрөмжийг угсарч суурилуулсан 6.6 сая, ТӨБЗГ-ын 2021 оны А-1/424 албан тоотой үнэ төлбөргүй Дархан -уул аймгийн орон нутгийн өмчийн газраас хүлээн авсан 418.8 сая төгрөгийн хөрөнгийн дүнгээр нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2021 оны 127, А-1/655 дугаар тогтоолоор акталсан 102.1 сая төгрөгийн хөрөнгийн дүнгээр буурсан байна.

Биет бус хөрөнгө 17.7 сая төгрөгөөр өссөн нь 1.4 сая төгрөгийн дахин үнэлгээ хийгдсэн, 19.5 сая төгрөгөөр дулааны горимын тооцооны программ худалдан авснаас шалтгаалжээ.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд аж ахуйн нэгж байгууллагад өгөх өглөг 596.4 сая төгрөг, төсөвт ажлын өглөг 129.1 сая төгрөг, татварын өглөг 1,072.1 сая төгрөг, урьдчилж орсон орлого 2.9 сая төгрөгийн өр төлбөрүүд байна. Урт хугацаат өр төлбөр дансанд төсвийн хөрөнгө оруулалтаарх татаас санхүүжилтийн алдагдлын 18.4 сая төгрөгийн хойшлогдсон орлогын үлдэгдэлтэй байна.

Шалгагдагч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт компанийн тайлант хугацаанд гарсан өртөг, зардлын ашиглалт, засвар, үйлчилгээ, ерөнхий удирдлага, борлуулалт маркетинг гэсэн өртгийн төвүүдэд аккрузал сууриар бодитой, үнэн зөв тооцож, тайлант хугацаанд нь зохистой ангилж, хуваарилж бүртгэх, үйл ажиллагааны бусад зардлыг аккрузал сууриар зөв, тооцож бүртгэхээр заасан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, бусад зардал гэж ангилсан байна.

Зардал өмнөх онтой харьцуулахад үйлдвэрлэл, үйлчилгээний цалингийн зардал 233.2 сая төгрөгөөр, бусад зардал 58.4 сая төгрөгөөр хасагдсан нь ажилчдын орон тоо, үр дүнгийн урамшууллын хэмжээг бууруулсан, бараа ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөний биелэлтээс шалтгаалжээ.

Үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөгт худалдаж авсан нүүрс, цахилгааны зардал, авто хэсэг, үйлдвэрлэл техник хангамжийн хэсгүүдийн ажилчдын цалин, хөдөлмөр хамгаалал, ашиглалтын зардал, сэлбэг хэрэгсэл, урсгал засвар, шатах тослох материал, албан томилолт, барилга байгууламж, тоног төхөөрөмжийн элэгдлийн зардал, төсөвт төлсөн татвар хураамжуудыг хамруулсан байна.

#### **4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Дулаан шарын гол ТӨХК-ийн гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний сайдын 2021 оны А/25 дугаар тушаалаар 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны

нийт орлогыг 3,104.7 сая төгрөгөөр, нийт зардлыг 3,650.0 сая төгрөгөөр, 545.3 сая төгрөгийн алдагдал байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 46.5 сая төгрөгийг төлөвлөсөн байна. Эрчим хүчний сайдын 2021 оны А/164 дугаар тушаалаар нийт орлогыг 44.8 сая төгрөгөөр бууруулж, алдагдлыг 44.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна.

Гүйцэтгэлээр 3,032.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 3,216.8 сая төгрөгийн зардал гарган, 184.7 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 3,32.1 сая төгрөг болж, төлөвлөснөөс 27.8 сая төгрөг буюу 0.9 хувиар тасарсан нь цэвэр борлуулалт 99.9 сая төгрөгөөр буюу 4.0 хувийн дутуу гүйцэтгэл нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 3,216.8 сая төгрөг болж, төлөвлөснөөс 433.2 сая төгрөг буюу 11.9 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь цалингийн зардал 316.3 сая төгрөгөөр, хөдөлмөр хамгааллын зардал 34.6 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ 21.7 сая төгрөгөөр буурснаас шалтгаалжээ.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 3 нэр төрлийн 9 ажилд өөрийн эх үүсвэрээс 94.7 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд алдагдал 184.6 сая төгрөг болж, төлөвлөснөөс 405.4 сая төгрөгөөр бууруулсан нь үндсэн бус үйл ажиллагааны орлого 72.2 сая төгрөгөөр давсан, зардал 433.2 сая төгрөг буюу 11.9 хувиар дутуу зарцуулсантай холбоотой байна.

## **5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### **5.1 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дулаан шарын гол ТӨХК нь тайлант онд нийт 2,807.9 сая төгрөгийн 171 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас орлого, зарлагын 95.4 сая төгрөгийн 8 мэдээллийг байршуулж мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална: 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, 4.1.3. тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх,” гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх.

## 5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Компани нь 3.4 сая төгрөгийн шагнал урамшууллын зардал гаргасан нь Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3-д “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нээж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгалын зардлыг гаргахгүй байх;” гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх;

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна гэж дүгнэлээ.

## 6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 102.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 102.0 сая төгрөгийг залруулж, зөрчлийг арилгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 449.0 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 271.0 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 177.9 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгч, хэрэгжилт 75.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	271.0	1	37.7	1	233.3	50.
Зөвлөмж	2	177.9	2	177.9	-		100
Нийт дүн	4	449.0	3	215.6	1	233.3	75

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. Шилэн дансны алдаа, зөрчил давтан гарсан асуудалд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

## 7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

2021 оны 2 дугаар сарын 23-ны өдөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Шийдвэр гүйцэтгэх албаны “Эд хөрөнгө битүүмжлэх тухай тогтоолоор” 383.6 сая төгрөг гаргуулах төлбөрийг барагдуулаагүй тохиолдолд компанийн эзэмшлийн Ландкрузер 150 прадо маркийн 6119ДАХ улсын дугаартай суудлын автомашиныг хураахаар битүүмжилснийг дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 30.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 29.9 сая төгрөгийн алдааг залруулж, 0.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

Залруулагдаагүй 0.7 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 34.9 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

## 8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 29.9 сая төгрөгийн техник эдийн засгийн үнэлгээ хийлгэсэн гэрээний төлбөрийг биет бус хөрөнгөөр бүртгэснийг залруулав.

## 8.2 Төлбөрийн акт

Тайлант онд тахилга тайлалд 0.1 сая төгрөг, тэмцээн уралдаан арга хэмжээнд 0.6 сая төгрөг нийт 0.7 сая төгрөг зарцуулсан нь Засгийн газрын 43 дугаар тогтоолын 1.3 “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгалын зардлыг гаргахгүй байх;” гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

## 8.3 Албан шаардлага

Байгууллагын авлага 428.9 сая төгрөг, өглөг 762.9 сая төгрөг болж өссөн ба өр төлбөрийн үлдэгдэлд 1,072.1 сая төгрөгийн татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй, 2020 он, 2021 оны хөрөнгө оруулалтын зардлыг бүрэн санхүүжүүлэх эх үүсвэргүй болсноос аж ахуйн нэгж байгууллагад төлөх өр төлбөр өсөж, төлбөрийн чадвар нь улам суларч байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн “20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;” Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн “61.1.3.компанийн алдагдал тухайн тайлант үеийн эцэст өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтэрсэн;”, 61.1.4.компанийн өр нь хоёр жил дараалан өөрийн хөрөнгөөс илүү болж, хасах утгатай болсон;” НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, 25 дугаар параграф. “Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага нь үйл ажиллагаагаа тасралтгүй байдлаар үргэлжлүүлэн явуулах уг аж ахуйн нэгжийн чадвар боломжийг үнэлэх хэрэгтэй. Ийм үнэлгээг хийх үедээ удирдлага нь тасралтгүй байдлаар үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах уг аж ахуйн нэгжийн чадварт мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал буюу нөхцөл байдалтай холбоотой материаллаг эргэлзээтэй байдлыг мэдсэн тохиолдолд аж ахуйн нэгж нь тэдгээр эргэлзээтэй байдлын талаар тодруулга хийх хэрэгтэй.” гэсэн заалтуудтай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх;

Дээрх төлбөрийн акт, албан шаардлагуудын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс										
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж		
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Санхүүгийн тайлангийн асуудлаар																	
1	Дулаан шарын гол ТӨХК	АХГ-2022/105/НА-СТА-ТӨА	Тахилга тайлал, тэмцээн уралдааны арга хэмжээнд 687,346.19 төгрөг зарцуулж Засгийн газрын 43 дугаар тогтоолыг зөрчсөн.	Төлбөрийн акт тогтоосон	1	687.3			1	687.3							
2	Дулаан шарын гол ТӨХК	АХГ-2022/105/НА-СТА-ТӨА	29.9 сая төгрөгийн техник эдийн засгийн үнэлгээ хийлгэсэн гэрээний төлбөрийг биет бус хөрөнгөөр холбогдох стандартыг зөрчсөн.	Урьдчилж төлсөн зардал дансанд бүртгэж залруулсан.	1	29,900.0	1	29,900.0									
3	Дулаан шарын гол ТӨХК	АХГ-2022/105/НА-СТА-ТӨА	Байгууллагын авлага 428.9 сая төгрөг, өглөг 762.9 сая төгрөг болж өссөн ба өр төлбөрийн үлдэгдэлд 1,072.1 сая төгрөгийн татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй; 2020 он, 2021 оны хөрөнгө оруулалтын зардлыг бүрэн санхүүжүүлэх эх үүсвэргүй болсоноос аж ахуйн нэгж байгууллагад төлөх өр төлбөр өсч, төлбөрийн чадвар нь улам суларсан.	Албан шаардлага хүргүүлсэн	1						1						
ДҮН					3	30,587.3	1	29,900.0	1	687.3	1	-					
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																	



1	Дулаан шарын гол ТӨХК	АХГ-2022/105/НА-СТА-ТӨА	Шилэн дансанд 95.4 сая төгрөгийн 8 мэдээллийг байршуулаагүй.	Хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.	1	95,429.8						1	95,429.8			
2	Дулаан шарын гол ТӨХК	АХГ-2022/105/НА-СТА-ТӨА	Байгууллагын оны аваргуудын шагналд 3.4 сая төгрөг олгож Засгийн газрын 43 дугаар тогтоолыг зөрчсөн.	Албан шаардлага хүргүүлсэн	1	3,380.0					1	3,380.0				
<b>ДҮН</b>					2	98,809.8					1	3,380.0	1	95,429.8		
<b>НИЙТ ДҮН</b>						<b>129,397.1</b>	<b>1</b>	<b>29,900.0</b>	<b>1</b>	<b>687.3</b>	<b>2</b>	<b>3,380.0</b>	<b>1</b>	<b>95,429.8</b>		



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 408/А.0150055  
АХГ-2022/105/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Дулаан шарын гол ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Компанийн авлага 428,951,169 төгрөг, өглөг 762,956,446 төгрөг болж өссөн ба өр төлбөрийн үлдэгдэлд 1,072,085,209 төгрөгийн татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өртэйгөөс 2020 он, 2021 оны хөрөнгө оруулалтын зардлыг бүрэн санхүүжүүлэх эх үүсвэргүй болж, аж ахуйн нэгж байгууллагад төлөх өр төлбөр өсч, төлбөрийн чадвар нь улам суларсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.3 "компанийн алдагдал тухайн тайлант үеийн эцэст өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтэрсэн", 61.1.4 "компанийн өр нь хоёр жил дараалан өөрийн хөрөнгөөс илүү болж, хасах утгатай болсон", НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, 25 дугаар параграф "Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага нь үйл ажиллагаагаа тасралтгүй байдлаар үргэлжлүүлэн явуулах уг аж ахуйн нэгжийн чадвар боломжийг үнэлэх хэрэгтэй. Ийм үнэлгээг хийх үедээ удирдлага нь тасралтгүй байдлаар үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах уг аж ахуйн нэгжийн чадварт мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал буюу нөхцөл байдалтай холбоотой материаллаг эргэлзээтэй байдлыг мэдсэн тохиолдолд аж ахуйн нэгж нь тэдгээр эргэлзээтэй байдлын талаар тодруулга хийх хэрэгтэй" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө."; Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлага, өр төлбөрийг барагдуулах арга хэмжээ авч ажиллан биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дулаан шарын гол ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Б.Батхуяг, ерөнхий нягтлан бодогч Ж.Даш нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ШИНЭ ИХ ТЭРБУМ АУДИТ ХХК-ИЙН  
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Ц.ХОСЖАРГАЛ  
Т.МЕРУЕРТ

9006109  
9019120396

Монгол Улс: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\0.10.10.20\Bichig\_Khereg\Alban Shaardlaga\2022\03\5 Auditin 2 Gazar-80.Docx

0010801141



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 409/А.0150055  
АХГ-2022/105/НБ-СА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Дулаан шарын гол ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Компани нь 3,380,000.00 төгрөгийн шагнал урамшууллын зардал гаргасан.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3 "Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгалын зардлыг гаргахгүй бай;" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө."; Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, хөрөнгийг үр ашигтай зарцуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дулаан шарын гол ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Б.Батхуяг, ерөнхий нягтлан бодогч Ж.Даш нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ШИНЭ ИХ ТЭРБУМ АУДИТ ХХК-ИЙН  
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Ц.ХОСЖАРГАЛ  
Т.МЕРУЕРТ

Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-204230

\\10.10.10.20\Bichig\_Khereg\Alban\_Shaardlaga\2022\0315\_Auditin\_2\_Gazar-81.Docx

0010801143



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 410/А.0150055

Улаанбаатар хот

АХГ-2022/105/НА-СТА-ТӨА

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Дулаан шарын гол ТӨХК-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 95,429,897.00 төгрөгийн ажил гүйлгээний 8 мэдээллийг байршуулаагүй, өмнөх оны зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын холбогдох заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.2-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Зөрчил гаргасан буруутай албан тушаалтанд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Дулаан шарын гол ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Б.Батхуягт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:  
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ШИНЭ ИХ ТЭРБУМ АУДИТ ХХК-ИЙН  
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Ц.ХОСЖАРГАЛ

Т.МЕРУЕРТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15 № 49/А0150055

Улаанбаатар хот

АХГ-2022/105/НБ-СТА-ТБ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Дулаан шарын гол ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд тахилга тайлалд 121,818.19 төгрөг, тэмцээн уралдаан зохион байгуулахад зориулан 565,528.00 төгрөг, нийт 687,346.19 төгрөгийн үргүй зардал гаргасан байна.


Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3 "Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгалын зардлыг гаргахгүй байх" гэсэн заалт зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно." Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Тахилга тайлал, тэмцээн уралдааны арга хэмжээнд зарцуулсан 687,346.19 /Зургаан зуун наян долоон мянга гурван зуун дөчин зургаан/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Дулаан шарын гол ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Б.Батхуяг, ерөнхий нягтлан бодогч Ж.Даш нарт харууцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ШИНЭ ИХ ТЭРБУМ АУДИТ ХХК-ИЙН  
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Ц.ХОСЖАРГАЛ

Т.МЕРУЕРТ